

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2016 ОНЫ 12 ДУГААР ХУРАЛДААН**

Хуралдаан 2016 оны аравдугаар сарын 05-ны 14 цаг 06 минутад эхэлж, 16 цаг 42 минут хүртэл Засаг даргын Тамгын газрын даргын өрөөнд болж, нийт 2 цаг 36 минут үргэлжлэв.

№	Хэлэлцэх асуудлын төлөвлөгөө	Шийдвэр
1	Цагаандэлгэр, Адаацаг сумдын Соёлын төвийн эрхлэгч, Цагаандэлгэр, Гурвансайхан, Дэлгэрцогт, Сайхан-Овоо сумдын Эрүүл мэндийн төвийн эрхлэгч, Говь-Угтаал сумын сум дундын эмнэлгийн эрхлэгчийн албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалт дүнгийн тухай	Дэлгэрцогт, Гурвансайхан сумын ЭМТ-ийн эрхлэгчийн ажлын байранд нэр дэвшүүлэхээр оруулж ирсэн Адъяасүрэн, Урангоо нарыг шаардлага хангахгүй байгаа тул нэр дэвшүүлэхээс татгалзахаар болов.
2	Дэлгэрцогт сумын Хүний нөөцийн бодлого, төрийн албаны стандартын хэрэгжилтийн тайлан сонсгол	Тайлантай холбогдуулан салбар зөвлөлийн гишүүдээс сум, байгууллага тус бүрт өгөгдсөн үүрэг даалгаврыг нэгтгэн албан тоотоор Эрүүл мэндийн газрын дарга, дээрх сумдын Засаг дарга тус бүрт хүргүүлэх. Дээрх 3 байгууллагад нийтлэг байгаа асуудлыг шийдвэрлэх зөвлөмж гаргаж, сум, байгууллагын дарга нарт хүргүүлэхээр болов.
3	Цагаандэлгэр сумын Хүний нөөцийн бодлого, төрийн албаны стандартын хэрэгжилтийн тайлан сонсгол	
4	Эрүүл мэндийн газрын Хүний нөөцийн бодлого, төрийн албаны стандартын хэрэгжилтийн тайлан сонсгол	
5	Төрийн албаны мэргэшлийн шалгалтын комисс байгуулах	Дундговь аймагт 10 сард зохион байгуулагдах Төрийн албаны мэргэшлийн шалгалтын салбар комисс байгуулах тогтоолын төслийг батлав.
6	Адаацаг сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтыг зарлах тухай.	Адаацаг сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын ажлын байрны шаардлагын талаар тус сумын ИТХ-д санал тавьж засуулан, дахин зарлах.

САЛБАР ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА